

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4 сарын 29 өдөр

№ 1

Улаанбаатар хот


Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгож батлах тухай

“Компанийн тухай” хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Б.Энхтуул /Эрчим хүчний яамны мэргэжилтэн/, С.Мөнгөнцэцэг /Сангийн яамны хэлтсийн дарга/, Д.Нарангэрэл /Сангийн яамны хэлтсийн дарга/ нарыг 2016 оны 4 дүгээр сарын 29-ны өдрөөс эхлэн томилсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

Эрчим хүчний яамыг төлөөлж:


Д. ДЭЛГЭРЦОГТ

Сангийн яамыг төлөөлж:


В. ДАРХАНБААТАР

**“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 4 сарын 29 өдөр

№ 62

Улаанбаатар хот

**2015 оны тайлан тэнцлийн
дүнг батлах тухай**

“Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.10.10 дахь заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2015 оны жилийн тайлан тэнцлийн дүнгээр эргэлтийн хөрөнгийг 18,161,095,373.39 /Арван найман тэрбум нэг зуун жаран нэгэн сая ерэн таван мянга гурван зуун далан гурван төгрөг 39 мөнгө/ төгрөгөөр, эргэлтийн бус хөрөнгийг 191,702,344,006.85/ Нэг зуун ерэн нэгэн тэрбум долоон зуун хоёр сая гурван зуун дөчин дөрвөн мянга зургаан төгрөг 85 мөнгө/ төгрөгөөр, богино хугацаат өглөгийг 4,979,124,177.01 /Дөрвөн тэрбум есөн зуун далан есөн сая нэг зуун хорин дөрвөн мянга нэг зуун далан долоон төгрөг 01 мөнгө / төгрөгөөр, урт хугацаат өглөгийг 23,946,420,314.22 /Хорин гурван тэрбум есөн зуун дөчин зургаан сая дөрвөн зуун хорин мянга гурван зуун арван дөрвөн төгрөг 22 мөнгө/ төгрөгөөр, эздийн өмчийг 180,937,894,889.01 /Нэг зуун наян тэрбум есөн зуун гучин долоон сая найман зуун ерөн дөрвөн мянга найман зуун наян есөн төгрөг 01 мөнгө/ төгрөгөөр, нийт орлогыг 97,908,376,718.80 /Ерэн долоон тэрбум есөн зуун найман сая гурван зуун далан зургаан мянга долоон зуун арван найман төгрөг 80 мөнгө / төгрөг, нийт зардлыг 97,446,304,698.79 /Ерэн долоон тэрбум дөрвөн зуун дөчин зургаан сая гурван зуун дөрвөн мянга зургаан зуун ерэн найман төгрөг 79 мөнгө/ төгрөгөөр, цэвэр ашгийг 462,072,020.11 /Дөрвөн зуун жаран хоёр сая далан хоёр мянга хорин төгрөг 11 мөнгө /төгрөгөөр тус тус баталсугай.

2. Компанийн 2015 оны үйл ажиллагаанд дүгнэлт хийж, 2016 онд өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, санхүү төлбөрийн чадварыг сайжруулах, өр төлбөрийг барагдуулах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал нарт даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ**

Эрчим хүчний яамны төлөөлж:


Д.Дэлгэрцогт

Сангийн яамны төлөөлж:


В.Дарханбаатар

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4 сарын 29 өдөр

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг чөлөөлөх тухай

“Компанийн тухай” хуулийн 62.1.7 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 2016 оны 68 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүд болон хараат бус гишүүдийг 2016 оны 4 дүгээр сарын 29-ны өдрөөр тасалбар болгон нэгдүгээр хавсралтын ёсоор чөлөөлсүгэй.

2. Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдийг үргэлжлүүлэн ажиллахыг хоёрдугаар хавсралтын ёсоор зөвшөөрсүгэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

Эрчим хүчний яамыг төлөөлж:



Сангийн яамыг төлөөлж:



В.ДАРХАНБААТАР

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4 сарын 29 өдөр

№ 04

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.1 , 46.8 дахь заалт, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц “ төрийн өмчит хувьцаат компанийн 2015 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүнгээр тайлант үед 462,072,020.11 /дөрвөн зуун жаран хоёр сая далан хоёр мянга хорин төгрөг 11 мөнгө / төгрөгийн цэвэр ашигтай ажилласан тул цэвэр ашгийн 10 хувиар тооцож ногдол ашиг хуваарилсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

Эрний хүчний яамыг төлөөлж:



Д.ДЭЛГЭРЦОГТ

Сангийн яамыг төлөөлж:



В.ДАРХАНБААТАР

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4 сарын 29 өдөр

№ 05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны
зардлын төсөв батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт,
“Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн
дүрмийн 6 дугаар зүйлийн 6.10.8 дахь заалтыг тус тус үндэслэн Хувьцаа
эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат
компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны зардлын төсвийг
хавсралтад заасан 42670400 /Дөчин хоёр зургаан зуун далан мянга
дөрвөн зуун төгрөг/ төгрөгөөр баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтанд хяналт тавьж, мөрдөн ажиллах,
төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг тэдний ажлын үр дүн,
оролцоог харгалзан олгох, зардал хэтрүүлэхгүй ажиллахыг Төлөөлөн
удирдах зөвлөлийн дарга /Б.Сандуйжав/-т үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

Эрчим хүчний яамны төлөөлж:



Д.Дэлгэрцогт

Сангийн яамны төлөөлж:



В.Дарханбаатар

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 5 сарын 23 өдөр

№ 7

Улаанбаатар хот

Хараат бус гишүүдийг сонгож
батлах тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалтыг үндэслэн
Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр П.Цэрэннадмид, А.Шоовдор, Р.Мөнхтуяа нарыг 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн сонгож баталсугай.

2. Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН

ТӨЛӨӨЛӨГЧ

Эрчим хүчний яамыг төлөөлж:



Сангийн яамыг төлөөлж:


В.ДАРХАНБААТАР